



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГААС ОЛГОСОН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ



ХЭДС-аас хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний үр дүнгээр төлөвлөсөн ажлын байр нэмэгдээгүй, сургалтад хөрөнгө зарцуулж байгаа боловч эцсийн үр дүн болох ажилгүй иргэн ажилтай болсон байх асуудал орхигдсон, өмнөх онтой харьцуулахад хөдөлмөр эрхлэлтийн түвшин буурсан үзүүлэлттэй байна.

2021 он



Тайланг бэлтгэсэн: Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Аудитын менежер Г.Наранбаяр Ахлах Аудитор Ц.Батсайхан Аудитор Б.Анхтуяа 2021 оны 06 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70543179 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Аймгийн нутгийн удирдлагын ордон2 дугаар давхар, 205 тоот	Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 1.1 Сангийн орлогын эх үүсвэрийг төлөвлөхдөө Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулаагүй байна..... 7 1.1.1 Улсын төсвөөс авах санхүүжилтийг төлөвлөхдөө төсвийн төслийг Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлөөр хэлэлцүүлээгүй байна. 7 1.1.2 Орон нутгийн төсвөөс ХЭДС-д зарцуулах зардлын эх үүсвэр төлөвлөгдөөгүй байна..... 9 Аймгийн ХХҮГ-аас ХЭДС-гаас хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төсвийг төлөвлөхдөө зөвхөн улсын төсвөөс авах эх үүсвэрийг тооцоолж, орон нутгийн төсвөөс шаардагдах төсвийн тооцооллыг гаргаж, аймгийн ИТХ-д санал хүргүүлдэггүй байна. 9 Иймээс аймгийн ХЭДС-д 2019-2020 онд орон нутгийн төсвөөс зардлын эх үүсвэр төлөвлөж, батлагдаагүй байна..... 9 1.2.1 Сангийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэхдээ орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилаагүй байна. 9 1.2.2 Сангийн орлогын эх үүсвэрийг үнэн зөв бүртгэж тайлагнасан байна..... 9 2.1. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн сонгон шалгаруулах журмыг зөрчсөн, зорилтот бүлэгт хүргэх мэдээллийн ил тод байдал хангалтгүй байна. 10 2.1.1 Төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтын зар мэдээлэл зорилтот бүлэгт бүрэн хүрээгүй байна. 10 2.1.2 Хууль журмаа зөрчиж ажил хөдөлмөр эрхэлдэг, тогтмол орлоготой иргэдийг төсөлд сонгон шалгаруулсан байна..... 13 2.2. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн ажлын байр бий болоогүй, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2020 онд аймгийн хэмжээнд өмнөх оноос 6.2%-иар буурсан байна..... 15 2.2.1 Ковид цар тахлын улмаас сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагаа доголдож зогсонги байдалд орсон байна. 15 2.2.3 Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнг тооцож, дүн шинжилгээ хийгээгүй байна..... 17 2.3. ХЭДС-гийн хөрөнгийг хууль журамд нийцүүлэн олгож, үнэн зөв тайлагнасан байна. 19 2.3.1 Төсөл хэрэгжүүлэгч иргэн төслийн хөрөнгийн зориулалтыг өөрчлөн зарцуулсан байна. 19 2.3.2 ХЭДС-гийн хөрөнгийн зарцуулалтыг үнэн зөв тайлагнасан байна. 21
--	---



	3.1. Сангийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтын тогтолцоо үр нөлөөгүй, хөндлөнгийн байгууллагаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгээгүй байна.....	21
	3.1.1 ХЭДС-гийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих шат шатны дотоод хяналт үр нөлөөгүй байна.	21
	3.1.2 ХЭДС-гийн 2019 оны үйл ажиллагаанд аймгийн МХГ-аас хяналт шалгалт хийгдсэн бөгөөд хөндлөнгийн байгууллагаар ХШҮ хийлгээгүй байна.	22
	3.2.ХЭДС-гийн мэдээ, тайлангийн гүйцэтгэлийг үнэн зөв, хуулийн хугацаанд мэдээлсэн байна.	23
	3.2.1 ХЭДС-гийн орлого, зарлагын тайланг холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. .	23
	3.2.2 ХЭДС-гийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл гомдол, санал гараагүй байна.....	23
	3.2.3 ХЭДС-гийн орлого, зарлагын тайланг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн хугацаанд үнэн зөв, бүрэн мэдээлсэн байна.....	23
	Дүгнэлт	
	Зөвлөмж	
	Холбогдох байгууллагын санал	
	Холбогдох байгууллагын саналд хийсэн тайлбар	
	Хавсралтууд	



Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ГСА	Говьсүмбэр аймаг
ШТА	Шууд тайлагнах ажил
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОУ	Олон улс
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ТББ	Төрийн бус байгууллага
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ХЭАЗ	Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл
ЭЗНХҮЧ	Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл



Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөөг үндэслэн, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

2. Аудитын зорилт:

Говьсүмбэр аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2019, 2020 онд хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд Гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. ХЭДС-гийн орлогын эх үүсвэрийг холбогдох хууль, журмын дагуу бодитой төлөвлөж, бүрдүүлсэн эсэх
2. ХЭДС-гийн хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжид зааснаар зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, тайлагнасан эсэх
3. ХЭДС-гийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх

3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2019-2020 онд санхүүжүүлсэн 8 хөтөлбөрийн хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүнд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, хөтөлбөр, арга хэмжээг гүйцэтгэгч нарын үйл ажиллагааг хамрууллаа.

4. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 "Төрийн аудит, Тулгуур зарчим", MNS 6817-5:2020 "Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим", MNS 6817-7:2020 "Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудит" стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалын дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга авах, шалгагдагч байгууллагаас авсан судалгаа, санал асуулга, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, анхан шатны баримтаас хөөн шалгах, бодит байдал дээр оршин байгааг үзэх, ажиглалт хийх зэрэг аудитын горимуудыг ашиглав.



5. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Батсайхан, аудитор Б.Анхтуяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын талбарын ажлыг 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлүүлж, тайланг Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан шалгагдагч байгууллага болон холбогдох эрх бүхий албан тушаалтанд 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдөр хүргүүллээ.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл

Аудитын тайлан нь аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн бүтцээр үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

7. Хүндрэл бэрхшээл

Аудитын явцад хүндрэл бэрхшээл гараагүй.

8. Үндсэн мэдээлэл

ХЭДС-д 2019 онд 526,573.0 мянган төгрөг төлөвлөснөөс, төлөвлөгөөнд 4 удаа өөрчлөлт орж, 603,474.6 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, 396,478.8 мянган төгрөгийг зарцуулсан ба 206,995.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

2020 онд 557,224.0 мянган төгрөг төлөвлөснөөс, төлөвлөгөөнд 5 удаа өөрчлөлт орж, 478,865.7 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, 298,775.2 мянган төгрөгийг зарцуулж, 180,090.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

ХЭДС-аас хэрэгжүүлсэн 8 хөтөлбөр, арга хэмжээнд 2019 онд 396,478.8 мянга, 2020 онд 298,775.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

ХЭДС-гийн нийт авлага 2019 онд 371,912.5 мянга, 2020 онд 405,139.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.



Бүлэг 1

Орлогын төлөвлөлтөд орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилах боломжит нөхцөл байдлыг судлаагүй, аймгийн ИТХ-д санал хүргүүлээгүй байна

1.1 Сангийн орлогын эх үүсвэрийг төлөвлөхдөө Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулаагүй байна.

1.1.1 Улсын төсвөөс авах санхүүжилтийг төлөвлөхдөө төсвийн төслийг Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлөөр хэлэлцүүлээгүй байна.

ХЭДС-гийн төсвийг 2019 онд 361,100.0 мянга, 2020 онд 557,224.0 мянган төгрөгөөр тус тус төлөвлөсөн боловч 2019 онд 525,277.0 мянга, 2020 онд 308,400.0 мянган төгрөг батлагдсан байна.

Аймгийн ХЭДС-гийн 2019-2020 оны төсвийн төсөл, батлагдсан төсөв хүснэгтээр харуулбал

Хүснэгт №1

/мян.төг/

№	Зардлын нэр	Төсвийн төсөөлөл		Батлагдсан төсөв		Зөрүү	
		2019	2020	2019	2020	2019	2020
1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө	5,280.0	7,200.0	7,200.0	700.0	-1,920.0	6,500.0
2	Ажилд зуучлах үйлчилгээ	7,240.0	7,980.0	7,980.0	2,700.0	-740.0	5,280.0
3	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	19,140.0	13,620.0	13,620.0	6,360.0	5,520.0	7,260.0
4	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	144,760.0	234,420.0	210,660.0	123,427.2	-65,900.0	110,992.8
5	Залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	46,800.0	117,920.0	117,920.0	67,070.0	-71,120.0	50,850.0
6	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	55,000.0	71,250.0	71,250.0	20,060.0	-16,250.0	51,190.0
7	ХБИ-ний ажлын байр дэмжих хөтөлбөр	34,880.0	40,980.0	37,140.0	41,830.0	-2,260.0	-850.0
8	Ахмадын зөвлөх үйлчилгээ	17,200.0	23,400.0	20,400.0	21,420.0	-3,200.0	1,980.0
	Хөтөлбөрийн дүн	330,300.0	516,770.0	486,170.0	283,567.2	-155,870.0	233,202.8
1	Жижиг зээл					0.0	0.0
2	Хүүгийн хөнгөлөлт	800.0	1,750.0			800.0	1,750.0
3	Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг устгах	1,500.0	4,704.0	4,704.0	2,203.7	-3,204.0	2,500.3
4	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл	6,000.0	4,000.0	4,000.0	3,032.1	2,000.0	967.9
5	Хөдөлмөрийн харилцаа, үндсэн эрхийн хэрэгжилт	2,000.0	1,000.0	10,000.0	1,000.0	-8,000.0	0.0
6	Бүртгэл мэдээллийн сүлжээ ажиллуулах	2,000.0	5,000.0	9,229.0	7,712.0	-7,229.0	-2,712.0



7	Хөдөлмөрийн салбарын ажилтнуудын ХНЗ-ийн 3 талт хорооны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийгдэх чадавх бэхжүүлэх сургалт	4,000.0	5,000.0	1,778.0	2,385.0	2,222.0	2,615.0
8	Сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах	3,000.0	3,000.0	1,396.0	3,500.0	1,604.0	-500.0
9	Хөдөлмөр эрхлэлтийн судалгаа	2,500.0	5,000.0			2,500.0	5,000.0
10	Хөтөлбөрийн төслийн хяналт үнэлгээ	5,500.0	8,000.0	6,000.0	3,000.0	-500.0	5,000.0
11	Гарын авлага хэвлэмэл материал	3,500.0	3,000.0	2,000.0	2,000.0	1,500.0	1,000.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	30,800.0	40,454.0	39,107.0	24,832.8	-8,307.0	15,621.2
	Нийт дүн	361,100.0	557,224.0	525,277.0	308,400.0	-164,177.0	248,824.0

Хүснэгтээс харахад: 2019 онд төсвийн төслийг 164,677.0 мянга буюу 45.5%-иар нэмэгдүүлсэн бол 2020 онд 248,824.0 мянга буюу 44.5%-иар бууруулан баталсан байна.

Энэ нь ХЭҮЗ-ийн тогтоолоор хөдөлмөр эрхлэлтийн бодлого хөтөлбөрийг өөрчлөн баталдагтай холбоотойгоор төсөв батлагдсанаас хойш төсөвт тодотгол хийж, өөрчлөлт орсон байна.

ХЭДС-гийн төсвийг төлөвлөхдөө ХЭҮЗ-ийн 02 дугаар тогтоолоор батлагдсан дүрмийн дагуу аймгийн ХЭҮЗ-өөр хэлэлцүүлж батлуулдаг байна. Тус зөвлөл нь аймгийн засаг даргаар ахлуулсан орон тооны бус 11 гишүүнтэй үйл ажиллагаа явуулдаг байна.

Тус зөвлөл нь ХЭДС-гийн төсвийг Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, хяналт тавих журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д “Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага тухайн жилд орон нутагтаа хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, тэдгээрт сан болон дэд сангаас зарцуулах хөрөнгийн хэмжээг **аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөр хэлэлцүүлэн** хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад өмнөх оны 7 дугаар сарын 1-ний дотор хүргүүлнэ” гэж заасны дагуу хэлэлцүүлэх чиг үүрэгтэй боловч аймгийн ХЭДС-гийн 2019, 2020 оны төсвийн төслийг Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлөөр хэлэлцүүлээгүй байна.

Энэ нь тус сангаас хэрэгжүүлж буй хөтөлбөр, арга хэмжээ нь аймгийн урт болон богино хугацааны бодлогын баримт бичгүүд, орон нутагт хэрэгжиж буй бусад төсөл хөтөлбөртэй уялдахгүй батлагдах үр дагавартай байна.

Иймд, Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, хяналт тавих журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтуудыг хэрэгжүүлж ажиллах талаар Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.



1.1.2 Орон нутгийн төсвөөс ХЭДС-д зарцуулах зардлын эх үүсвэр төлөвлөгдөөгүй байна.

Аймгийн ХХҮГ-аас ХЭДС-гаас хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төсвийг төлөвлөхдөө зөвхөн улсын төсвөөс авах эх үүсвэрийг тооцоолж, орон нутгийн төсвөөс шаардагдах төсвийн тооцооллыг гаргаж, аймгийн ИТХ-д санал хүргүүлдэггүй байна.

Иймээс аймгийн ХЭДС-д 2019-2020 онд орон нутгийн төсвөөс зардлын эх үүсвэр төлөвлөж, батлагдаагүй байна.

1.2 ХЭДС-гийн эх үүсвэрийг хуульд заасан боломжит орлогын 80%-иар бүрдүүлсэн байна.

1.2.1 Сангийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэхдээ орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилаагүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т заасны дагуу 9 нэр төрлийн орлогын эх үүсвэр бүрдэхээр хуульчлагдсан байна.

2019-2020 онд сангийн орлогыг дараах 4 эх үүсвэрээр бүрдүүлсэн байна. Үүнд:

- Улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө
- Олон улсын байгууллагын зээл тусламж
- Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр
- Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгө

2019-2020 онд ХЭДС-д “аймгийн Засаг дарга тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, дэд санд төвлөрүүлнэ” гэж заасан боловч Орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилаагүй байна.

Энэ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т “орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө”, “Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2-т “Дэд санд аймаг, нийслэл, дүүргийн төсвөөс жил бүр олгох хөрөнгийн хэмжээ нь тухайн төсвийн орлогын 0.3 хувиас доошгүй байна”, 2.3-т “Орон нутгийн төсвөөс хуваарилах хөрөнгийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, дэд санд төвлөрүүлнэ” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд дээрх хууль, журмын заалтын хүрээнд аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санг байгуулах хэрэгцээ шаардлага байгаа эсэх, санд орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилах нөхцөл боломжийг судлах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.2.2 Сангийн орлогын эх үүсвэрийг үнэн зөв бүртгэж тайлагнасан байна.

Аймгийн ХЭДС-д 2019 онд 4 нэр төрлийн 713,238.0 мянга, 2020 онд 4 нэр төрлийн 478,865.7 мянган төгрөгийн орлого төвлөрснийг НББ, тайланд үнэн зөв бүртгэж тайлагнасан байна.



ХЭДС-гийн орлогын эх үүсвэрийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 2

/мян.төг/

№	Орлогын нэр төрөл	2019	2020	Зөрүү	Хувиар
1	Улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө	506,242.2	310,032.1	-196,210.1	-38.7
2	Олон улсын байгууллагын зээл тусламжийн орлого		5,722.0	5,722.0	100.0
3	Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр,	46,077.4	17,361.3	-28,716.1	-62.3
4	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгө	160,822.4	145,750.3	-15,072.1	-9.4
5	Бусад орлого	96.0		96.0	100
Нийт дүн		713,238.0	478,865.7	-234,372.3	-32.8

Хүснэгтээс харахад: Сангийн орлого 2020 онд өмнөх оноос 234,372.3 мянган төгрөгөөр буюу 32.8 хувиар буурсан нь Ковид 19 цар тахлын улмаас төсвийн тодотголоор санхүүжилт хасагдсан, 2020 онд ХБ буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуй нэгж, байгууллагаас төлбөр төлөхийн оронд ХБИ-ийг авч ажиллуулдаг болсон зэргээс тухайн орлогууд тус тус буурснаас шалтгаалсан байна.

Дэлхийн банкны санхүүжилтээр 2020 онд Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр хэрэгжүүлэхээр 5,722.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон боловч Ковид 19 цар тахлаас шалтгаалж тус хөтөлбөр хэрэгжээгүй санхүүжилт нь буцаан татагдсан байна.

ХЭДС-гийн хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжид зааснаар зориулалтын дагуу зарцуулж, тайлагнасан эсэх

Бүлэг 2

ХЭДС-гийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан боловч **төсөл**, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг тооцож дүн шинжилгээ хийгээгүй байна.


2.1. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн сонгон шалгаруулах журмыг зөрчсөн, зорилтот бүлэгт хүргэх мэдээллийн ил тод байдал хангалтгүй байна.

2.1.1 Төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтын зар мэдээлэл зорилтот бүлэгт бүрэн хүрээгүй байна.

Аймгийн ХХҮГ нь ХЭДС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулах зар мэдээллийг иргэд, олон нийтэд шуурхай хүргэх зорилгоор Холбооны газар, Төч смарт Солюшн ХХК-тай хамтран ажиллах гурвалсан гэрээг байгуулсан ба дараах чиглэлээр зар мэдээг хүргэж ажилласан байна. Тухайлбал:




Дүрслэл №1 Зар мэдээг хүргэсэн байдал



Дүрслэл № 2

2019 оныг **“Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”** болгосонтой холбогдуулан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2019-2020 оны хөтөлбөрүүдийг танилцуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, хууль тогтоомжийн талаарх мэдээллийг орон нутгийн иргэдэд хүргэх, сурталчлах, таниулах, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор зохион байгуулсан ажлуудыг Дүрслэл 2-оор харуулав.



2019 онд аймаг болон сумдын хэмжээнд нээлттэй хаалганы өдөрлөгийг 2 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 1300 иргэн, ажил олгогчид, 2020 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, батлагдсан төсвийн талаарх мэдээллийг ажил олгогч иргэдэд сурталчилж, 6 хөтөлбөрийн 500 ширхэг гарын авлагыг иргэдэд тараасан талаар тайланд тусгасан байна.

Дэлхий дахинд үүсээд буй корона вируст халдварын нөхцөл байдлын улмаас 2020 онд олон нийтийг хамарсан өдөрлөг, арга хэмжээ зохион байгуулаагүй байна.

Аудитын явцад олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан “ХЭДС-гийн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт”-ийн талаар иргэд, олон нийтээс санал асуулга авсан ба санал асуулгад нийт 100 хүн хамрагдсан байна.



Диаграмм № 1


■ ХЭДС-гийн санхүүжилтээр хэрэгжүүлдэг төсөл, хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээллийг та хаанаас авдаг вэ?



ХЭДС-гийн санхүүжилтээр хэрэгжүүлдэг төсөл, хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээллийг та хаанаас авдаг вэ? санал асуулгад нийт 100 хүн хамрагдсанаас 55 буюу 55% нь олон нийтийн цахим хуудас, 19 буюу 19.0% нь тухайн байгууллагын ажилчдаас, 4 буюу 4% нь найз нөхдөөсөө, 4 буюу 4% нь холбооны зар мэдээ, 18 буюу 18.0% нь огт мэдээлэл авч чаддаггүй гэж хариулсан байна.

Диаграмм №2

■ ХЭДС-гийн санхүүжилтээр хэрэгжүүлдэг төсөл, хөтөлбөрт ямар иргэд хамрагдах боломжтой гэж та боддог вэ?



ХЭДС-гийн санхүүжилтээр хэрэгжүүлдэг төсөл, хөтөлбөрт ямар иргэд хамрагдах боломжтой гэж та боддог вэ? санал асуулгад

Нийт 100 хүн хамрагдсанаас 60 буюу 60% нь ажилгүй, орлогогүй иргэд, 26 буюу 26.0% нь бизнесийн үйл ажиллагаа явуулж буй бүх иргэд, 5 буюу 5.0% нь залуучууд, 3 буюу 3% нь ахмад настан, 2 буюу 2% нь малчин, 4 буюу 4% нь бусад иргэд хамрагддаг гэж тус тус хариулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаатай холбоотой иргэдээс ирүүлсэн санал хүсэлт:

- ✚ Мэдээлэл маш дутмаг байдаг
- ✚ Иргэдэд сурталчилгаа мэдээллийг сайн өгөх, төсөл бичих заавар зөвлөгөө өгөх
- ✚ Иргэдэд ил тод нээлттэй бус байдаг
- ✚ Мэдээлэл маш хангалтгүй, хэдэн төсөл ирээд хэд нь шалгарсан талаар мэдээлэл байдаггүй гэсэн байна.

Төсөл хөтөлбөрийг сурталчлах зорилгоор тодорхой арга хэмжээнүүдийг зохион байгуулж, мэдээллийн эх сурвалжийг ашиглаж байгаа боловч ХЭДС-гийн гол хэрэглэгч болох зорилтот бүлгийн иргэдэд мэдээллийг оновчтой хүртээмжтэй үр дүнтэй байдлаар хүргэх үйл ажиллагаа дутмаг байна. Зорилтот бүлгийн хэрэглэгч нь бичиг үсгийн чадваргүй, мэдээлэл авах болон техник технологи хэрэглэх чадвар боломж бүрдээгүй зэрэг нөхцөл шалтгаантай байдаг нь мэдээллийг цаг тухайд нь хүртээмжтэй олж авахад хүндрэл бэрхшээл үүсгэж байна.



Иймд тухайн жилд хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл хөтөлбөр болон сонгон шалгаруулалтын зар мэдээллийг зорилтот хэрэглэгчдэд үр дүнтэй хүргэх ажлыг зохион байгуулах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.1.2 Хууль журмаа зөрчиж ажил хөдөлмөр эрхэлдэг, тогтмол орлоготой иргэдийг төсөлд сонгон шалгаруулсан байна.

ХЭДС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэгт хамрагдах арга хэмжээг батлагдсан хөтөлбөр, удирдамжийн дагуу ХНХЯ-ны сайдын тушаалаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ арга хэмжээний зардал”-ын жишиг хэмжээг баримталж, хөрөнгийг зарцуулж ирсэн байна.




Дүрслэл №3

ХЭДС-гаас нийт 5 хөтөлбөрийн хүрээнд ажлын байрыг дэмжих, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ХБИ-ийн ажлын байрыг дэмжих, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр санхүүгийн дэмжлэг олгож байна.

Хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэгт хамрагдах иргэдийн төслийг сонгон шалгаруулах ажлын хэсэгт ХЭАЗ-ийн гишүүн, аймаг, сумдын

төрийн болон ТББ-ын төлөөллийг оролцуулж, ХХҮГ-ын даргын тушаалаар ажлын хэсэг томилж, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэх хуудсаар хяналт тавьж, ажлын хэсгийг хараат бусаар шийдвэр гаргах нөхцөлийг хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна.

Диаграмм №3



2019-2020 онд ХЭДС-гийн 5 хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 144 төсөл ирүүлснээс 98 төслийг сонгон шалгаруулсан байна.

2019, 2020 онд олгосон төсөл, хөтөлбөрийн сонгон шалгаруулалтын баримт материалыг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- 2019 онд залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд шалгарсан 1 төсөлд даргын шийдвэр гаргалгүй санхүүгийн дэмжлэг олгосон
- 2019 онд ХБИ-ийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд шалгарсан 1 төслийн батлан даалтын гэрээ даргын гарын үсгээр баталгаажаагүй
- 2019 онд ажлын байрыг дэмжих хөтөлбөрт ирүүлсэн төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн хурлын тэмдэглэлд ажлын хэсгийн дарга гарын үсэг зураагүй



- ✚ 2019 онд ажил хөдөлмөр эрхэлдэг 1 иргэнд санхүүгийн дэмжлэг олгосон байна. /Хавсралт 1-ээс дэлгэрэнгүйг үзнэ үү /

Энэ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, ажил олгогч энэ хуульд заасны дагуу хамрагдана”, 23 дугаар зүйлийн 23.1.7-т “малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих”, 23.1.8-т “ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 “Сангийн хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23.1-д заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулна”, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 1 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан 3 дугаар хавсралтаар батлагдсан “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн 8 дугаар зүйлийн 8.2.3-т “Залуучуудын аж ахуй, бизнес, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч нарыг хуульд заасан журмын дагуу хамруулах, төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтын баримт материалыг бүрэн бүрдүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аудитын явцад олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан “ХЭДС-гийн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт”-ийн талаар иргэд, олон нийтээс санал асуулга авсан ба санал асуулгад нийт 100 хүн хамрагдсан байна.

Диаграмм №4

- ✚ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалт үнэн зөв, шударга, нээлттэй ил тод явагддаг уу?



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалт үнэн зөв, шударга, нээлттэй ил тод явагддаг уу? гэсэн асуулгад нийт 100 хүн хариулсан ба

45 буюу 45.0% нь тийм, 17 буюу 17% үгүй, 38 буюу 38% нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаатай холбоотой иргэдээс ирүүлсэн санал хүсэлт:

- ✚ Шалгаруулалт нь сунжруу хугацаа урт санагдсан
- ✚ Танил тал, эрх мэдэлтэй хүмүүс хамрагддаг
- ✚ Хэдэн төсөл ирснээс хэд шалгарсан талаар мэдээлж байх
- ✚ Хүнд нь тааруулж холбогдох материалыг шаардаж шалгаруулдаг
- ✚ Хүнд суртал ихтэй
- ✚ Маш олон шаардлага тавьдаг, чирэгдэл ихтэй



✚ Хэт их шалгуур үзүүлэлттэй, шалгаруулахдаа шударга бодит байдлыг үнэлдэггүй гэсэн байна.

Санал асуулгын дүнгээс харахад 55 буюу 55.0% нь сонгон шалгаруулалтыг үнэн зөв, шударга, нээлттэй ил тод явагддаггүй, хүнд суртал ихтэй, танил, тал эрх мэдэлтэй хүмүүс хамрагддаг, мэдэхгүй гэж хариулсан байгаа тул цаашид төсөл хөтөлбөрт хамрагдах сонирхолтой иргэд олон нийтэд сонгон шалгаруулалтын журам дүрэм заавраа нарийвчлан танилцуулах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сонгон шалгаруулалтыг нээлттэй ил тод зохион байгуулж ажиллах нь зүйтэй юм.

2.2. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн ажлын байр бий болоогүй, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2020 онд аймгийн хэмжээнд өмнөх оноос 6.2%-иар буурсан байна.

2.2.1 Ковид цар тахлын улмаас сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагаа доголдож зогсонги байдалд орсон байна.

2019-2020 онд ХЭДС-гийн 5 хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 98 төслийг сонгон шалгаруулж, нийт 468,500.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөх нөхцөлтэй олгосон байна. Санхүүгийн дэмжлэгийг хөтөлбөр тус бүрээр харуулбал:

Хүснэгт №3

/мян.төг /

Хөтөлбөрийн нэр	Төслийн тоо	Олгосон санхүүгийн дэмжлэгийн мөнгөн дүн
2019 он		
Ажлын байрыг дэмжих	23	96,500.00
Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	10	93,000.00
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	11	53,000.00
ХБИ-ийн ажлын байрыг дэмжих	8	25,000.00
Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх	4	12,000.00
Нийт	56	279,500.00
2020 он		
Ажлын байрыг дэмжих	16	68,000.00
Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	6	60,000.00
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	4	20,000.00
ХБИ-ийн ажлын байрыг дэмжих	8	26,000.00
Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх	8	15,000.00
Нийт	42	189,000.00

Хүснэгтээс харахад: 2019 онд 56 төсөлд 279,500.0 мянга, 2020 онд өмнөх онтой харьцуулахад 25%-иар бага буюу 42 төсөлд 189,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг тус тус олгосон байна.

Аудитын явцад ХЭДС-гаас 2019 онд олгосон жижиг зээлийн 6 төсөл, санхүүгийн дэмжлэг олгосон 39 төсөл, 2020 онд олгосон жижиг зээлийн 3 төсөл, санхүүгийн дэмжлэг олгосон 40 төсөл нийт 88 төслийн үйл ажиллагаатай танилцахаар төлөвлөснөөс 13 төсөл хэрэгжүүлэгч эзгүй байсан бөгөөд 75 төсөлтэй танилцахад төслийн үйл ажиллагаанд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:



2019 онд:

- Жижиг зээлээс “Хос оёдол” төсөл хэрэгжүүлэгч нийт 3 ажлын байр бий болгоно гэж гэрээ байгуулсан боловч гэрээний үүргээ биелүүлээгүй, төлөвлөсөн ажлын байрыг бий болгоогүй, зөвхөн өөртөө ажлын байр бий болгосон байна.
- Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрөөс “Хос хүүхэлдэй”, “Хоёр эрдэнэ”, “Од кофе шоп” гэсэн нийт 3 төсөл хэрэгжүүлэгч ковид-19 цар тахал өвчний улмаас үйл ажиллагаа нь зогссон, 6 төсөл хэрэгжүүлэгч сайн дурын даатгалд хамрагдаагүй байна.
- Ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс “Цолмон салон” ажиллуулахаар зээл авсан иргэн төслөө хэрэгжүүлэлгүй, зээлийг эргэн төлж дуусгасан, 8 төсөл хэрэгжүүлэгч сайн дурын даатгалд хамрагдаагүй байна.
- ХБИ-ийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс “Блок үйлдвэрлэх” төсөл ковид-19 цар тахал өвчний улмаас үйл ажиллагаа зогссон байна.

2020 онд:

- Жижиг зээлээс “Орчин үеийн тоног төхөөрөмжтэй уламжлалт эмнэлэг”, “Боржигин голомт”, “Эрүүл хүнс амьдралын баталгаа” гэсэн 3 төсөл хэрэгжүүлэгч нийт 9 ажлын байр бий болгоно гэж гэрээ байгуулсан боловч гэрээний үүргээ биелүүлээгүй, төлөвлөсөн ажлын байрыг бий болгоогүй, сайн дурын даатгалд хамрагдаагүй байна.

Зураг №1



Зураг №2



- Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрөөс 1 буюу “Бялуу үйлдвэрлэл” төсөл хэрэгжүүлэгч үйл ажиллагаа явуулаагүй, төсөлд заасан тоног төхөөрөмжөө аваагүй

- ХБИ-ийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс “Бүжгийн сургалт” төсөл тоног төхөөрөмжийн татан авалт хийгээгүй байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэг авсан нийт 19 иргэний бүртгэлтэй малын тоог аймгийн Статистикийн хэлтсийн ирүүлсэн статистик мэдээтэй тулган баталгаажууллаа. Үүнд:

- 2020 онд 1 төсөл хэрэгжүүлэгч 94 мал худалдан авч малжуулах хөтөлбөрт хамрагдсан боловч статистик мэдээгээр жилийн эцэст малаа тоолуулаагүй байна.

ХЭДС-гаас санхүүжүүлсэн нийт 143 төслөөс 118 төсөл буюу 82.5% нь ковид-19 цар тахал өвчний улмаас үйл ажиллагаа нь зогсонги байдалд орж доголдсон, төслийг бүрэн хэрэгжүүлэх хүндрэл бэрхшээл учирсан, сангийн эргэн төлөлтөд эрсдэл учирч болзошгүй байна.

2.2.2 Хөтөлбөр тус бүрээр зорилтот түвшиндээ хүрч ажиллах шаардлагатай байна.

Аймгийн ХХҮГ нь жил бүр ХЭДС-гаар хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний зорилтот түвшинг батлан хэрэгжүүлж ирсэн байна.



2019-2020 оны зорилтот түвшин, гүйцэтгэлийг харьцуулан харуулбал:

/тоогоор /

№	Хөтөлбөрийн нэр	2019 он			2020 он		
		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хувь	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хувь
1	Хөдөлмөрт бэлтгэх хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	73	66	90.4	60	71	118.6
2	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	232	189	81.4	177	226	127.6
3	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	50	86	172.0	36	62	172.2
4	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	102	45	44.1	5	6	120.0
5	ХБИ-ийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр	50	39	78.0	21	24	114.2
6	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	14	23	164.0	13	15	115.3
7	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	1000	1030	103.0	-	245	-
8	Ажилд зуучлах үйлчилгээ	330	492	149.0	384	231	60.1
Дүн		1851	1970	106.4	696	880	126.4

Хүснэгтээс харахад: Хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд нийт дүнгээрээ зорилтот түвшиндээ хүрсэн боловч хөтөлбөр тус бүрээр 2019 онд 4 хөтөлбөр 44.1-90.4%, 2020 онд 1 хөтөлбөр 60.1%-тай хэрэгжиж зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй байна. Өмнөх онтой харьцуулахад 2020 онд зорилтот түвшинг бууруулж төлөвлөснөөс хүрсэн түвшин мөн өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

Зорилтот түвшиндээ хүрээгүй хөтөлбөрүүдийн шалтгаан нөхцөлийг тооцож үнэлээгүй байна.

Иймд зорилтот түвшинг өмнөх оны түвшингээс бууруулахгүй төлөвлөж, тухайн жилд дэвшүүлсэн зорилтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах, зорилтот түвшиндээ хүрээгүй хөтөлбөрүүдэд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, үнэлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.2.3 Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнг тооцож, дүн шинжилгээ хийгээгүй байна.

Аймгийн ХХҮГ нь ХЭДС-гаас 2019-2020 онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнг тооцож дүн шинжилгээ хийгээгүй байна.

Аудитын явцад аймгийн ХХҮГ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн даргаас **“2019-2020 онд ХЭДС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр нөлөө, үр дүнг тооцож, дүн шинжилгээ хийсэн эсэх”**-ийг ярилцлагын тэмдэглэлээр асууж тодруулахад дараах байдлаар хариулсан байна.

- 2019 онд ХЭДС-гийн хөтөлбөр, арга хэмжээнд 1972 иргэнийг хамруулж, 396,478.8 мянган төгрөгийг зарцуулсан, хэрэгжилт 80%, 2020 онд 897




иргэнийг хамруулж, 298,775.1 мянган төгрөгийг зарцуулж хэрэгжилт 85%-тай байгаа бөгөөд ХЭДС-гийн хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхдээ аймгийн ЭЗНХҮЧ-тэй уялдуулж, орон нутгийн төрийн захиргааны байгууллага, ААНБ-тай ажлын уялдаатай ажиллаж төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг.

Эндээс харахад хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүн, үр нөлөөг тооцож дүн шинжилгээ хийдэггүй байна.

Аудитын явцад олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан “ХЭДС-гийн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт”-ийн талаар иргэд, олон нийтээс санал асуулга авсан ба санал асуулгад нийт 100 хүн хамрагдсан байна.

Диаграмм №5

■ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрт хамрагдсанаар иргэдийн амьдралд үр нөлөө үзүүлж, дэмжлэг болж чадаж байгаа гэж та боддог уу?



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрт хамрагдсанаар иргэдийн амьдралд үр нөлөө үзүүлж, дэмжлэг болж чадаж байгаа гэж та боддог уу? асуулгад

Нийт 100 хүн хариулсан ба 62 буюу 62.0% нь тийм, 28 буюу 28% нь мэдэхгүй, 10 буюу 10.0% нь үгүй гэж хариулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаатай холбоотой иргэдээс ирүүлсэн санал хүсэлт:

- ✚ Төслийн санхүүжилтийн хэмжээ бага
- ✚ НДШ төлдөггүй иргэд төсөлд хамрагдах боломжтой учраас аль болох НДШ төлөхгүй үйл ажиллагаа явуулахыг эрмэлздэг болсон. Түүний оронд бизнес эрхэлдэг, ажилгүй иргэдийг ажлын байраар хангаж байгаа хүмүүс, ААНБ-д зориулж олгож байвал бодит дэмжлэг болох байх. Гарааны бизнесийг дэмжихдээ сайн бизнесийн санаанд хөрөнгө оруулалт хийх шаардлагатай гэсэн байна.

Санал асуулгын дүнгээс харахад төслийн санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх, гарааны бизнесийг дэмжихдээ сайн төслийг сонгон шалгаруулах шаардлага байгааг анхаарах нь зүйтэй байна.

Аудитын явцад ажилгүйдлийн болон хөдөлмөр эрхлэлтийн түвшинг улсын дундажтай харьцуулан харуулбал дараах байдалтай байна.

Диаграмм №6



Диаграммаас харахад: Ажилгүйдлийн түвшин 2019 онд манай аймагт улсын дундажтай ижил 10%, 2020 онд 9.8% буюу улстай харьцуулахад 2.2%-иар их, өмнөх онтой харьцуулахад 0.2%-иар буурсан байна.



Диаграммаас харахад: Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2019 онд манай аймагт 67.9% буюу улсын дунджаас 13.5%-иар их, 2020 онд 61.7% буюу улстай харьцуулахад 9%-иар их, өмнөх онтой харьцуулахад 6.2%-иар буурсан байна.

Ажилгүйдэл болон хөдөлмөр эрхлэлтийн түвшинг улсын дундажтай харьцуулахад эерэг үзүүлэлттэй байгаа бол өмнөх онтой харьцуулахад хөдөлмөр эрхлэлтийн түвшин буурсан үзүүлэлттэй байна.

2019-2020 онд ХЭДС-гийн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж ажилласнаар түр ажлын байр 338, байнгын ажлын байр 146 бий болгож, ажилгүй, ажил олоход хүндрэлтэй 723 иргэнийг ажил олгогчоос ирүүлсэн ажлын байранд зуучилсан талаар ажлын тайлан мэдээнд тусгасан байна.

ХЭДС-гаас хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд ажлын байр бий болгосон үр дүнг тооцохдоо нийгмийн даатгалд хамрагдсан байх шалгуур тогтоосон боловч хэрэгжилт хангалтгүй байна.

Аудитын явцад 2019-2020 оны ХЭДС-гийн санхүүжилтээр төсөл хэрэгжүүлэгч нийт 143 иргэний НДШ төлөлтийн лавлагааг аймгийн НДХ-ийн тоон мэдээлэлтэй тулган баталгаажууллаа. Үүнд:

- ✚ Төсөл хэрэгжүүлэгч иргэн, ААНБ-аас 25 буюу 17.5% нь нийгмийн даатгалд хамрагдсан
- ✚ 86 буюу 60.1% нь нийгмийн даатгалд хамрагдаагүй
- ✚ 32 буюу 22.4% нь давхар ажил эрхэлж байгаа

Үүнээс харахад төсөлд хамрагдсан нийт 143 иргэнээс 118 буюу 82.5% нь нийгмийн даатгалд хамрагдаагүй байгаа тул төслийн хүрээнд төлөвлөсөн ажлын байрыг бий болгож чадаагүй байна.


Түр болон байнгын ажлын байр бий болгосон, ажил зуучлалын тоо нэмэгдсэн, ажилгүйдлийн түвшин буурсан, хөдөлмөр эрхлэлтийн түвшин улсын дундажтай харьцуулахад өндөр гэсэн эерэг үзүүлэлтүүд гарсан боловч бодит байдалд төлөвлөсөн ажлын байр бий болоогүй, төсөл хөтөлбөрийн санхүүжилт иргэдийн амьдралд бодитой үр нөлөө үзүүлээгүй нь харагдаж байна. Энэ нь нэг талаар дэлхий даяар тархсан ковид-19 цар тахал өвчинтэй холбоотой байна.

Иймд төсөл хэрэгжүүлэгчийн нийгмийн даатгалд хамрагдах хувийг нэмэгдүүлэх, жижиг зээлийн хүрээнд ажлын байр бий болгохоор олгосон төслийн үр дүнг сайжруулж, талууд гэрээний үүргийг биелүүлэхэд анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.3. ХЭДС-гийн хөрөнгийг хууль журамд нийцүүлэн олгож, үнэн зөв тайлагнасан байна.

2.3.1 Төсөл хэрэгжүүлэгч иргэн төслийн хөрөнгийн зориулалтыг өөрчлөн зарцуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин / хувиар /





ХЭДС-гийн үйл ажиллагаанд 2019 онд 396,478.8 мянга, 2020 онд 298,775.1 мянган төгрөгийг тус тус зарцуулж, өмнөх онтой харьцуулахад зардал 24.6%-иар буурсан байна.

2019-2020 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийг нэр төрлөөр харьцуулан харуулбал

Хүснэгт №5

/мян.төг/

Хөтөлбөрийн нэр	2019			2020		
	Тоо	Мөнгөн дүн	Хувь	Тоо	Мөнгөн дүн	Хувь
Хөдөлмөрт бэлтгэх хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	66	6,720.0	1.7	71	6,360.0	2.1
Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	189	135,762.8	34.2	226	121,829.2	40.8
Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	86	98,630.0	24.9	62	66,870.0	22.4
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	45	56,540.6	14.3	6	20,060.0	6.7
ХБИ-ийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр	39	31,556.0	8.0	24	41,830.0	14.0
Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	23	19,945.0	5.0	15	19,711.0	6.6
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	1522	11,272.6	2.8	476	2,769.9	0.9
Бусад үйлчилгээ	4	36,051.8	9.1	17	19,345.1	6.5
Нийт	1972	396,478.8	100.0	897	298,775.1	100.0

Хүснэгтээс харахад: 2019-2020 онд ажлын байрыг дэмжих болон залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамгийн их буюу нийт хөрөнгийн 22.4-40.8%-ийг зарцуулсан байна. Энэ нь нэг төсөлд олгох хөрөнгийн хэмжээ бусад хөтөлбөртэй харьцуулахад өндөр төлөвлөгдөж ирдэгтэй холбоотой юм.

Аудитын явцад 2019-2020 онд ХЭДС-гаас хэрэгжүүлсэн төслийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалтыг анхан шатны баримт материалуудтай тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрсэн байна.

- Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрөөс 2020 онд “Бялуу үйлдвэрлэл” төсөл хэрэгжүүлэхээр 10,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон боловч төслөө хэрэгжүүлээгүй, төслийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, гэрээний үүргээ зөрчсөн
- Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд нийтийг хамарсан ажил арга хэмжээнд 2019-2020 онд 5 байгууллагатай гэрээ байгуулж, нийт 65,351.9 мянган төгрөгийг зарцуулсан боловч гэрээний биелэлтийг дүгнээгүй, үр дүнг тооцоогүй, гэрээнд гэрээ дүгнэх талаар заалт оруулаагүй
- Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах арга хэмжээнд Баянтал сумын иргэдтэй байгуулсан гэрээг ХХҮГ-ын дарга баталгаажуулаагүй, гэрээний биелэлтийг дүгнээгүй, үр дүнг тооцоогүй, гэрээнд гэрээ дүгнэх талаар заалт оруулаагүй

Дээрх зөрчлүүд нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно”, 33 дугаар зүйлийн 33.2-т “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ”, Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 5



угаар зүйлийн 5.6-т “Сан, дэд сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан гэм оуруутай албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага тооцно”, Захиргааны ерөнхий хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.3-т “Захиргааны гэрээ байгуулсан захиргааны байгууллага тодорхой бус”, 57 дугаар зүйлийн 57.1-т “Захиргааны байгууллага захиргааны гэрээний биелэлтийг хангах үүрэгтэй бөгөөд энэ тохиолдолд энэ хуулийн Наймдугаар бүлэгт заасан зохицуулалтыг хэрэглэнэ”, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 1 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 8 дугаар зүйлийн 8.9-т “Арга хэмжээний хүрээнд талуудын хамтран ажиллах гэрээний загвар, тайлангийн маягыг Хөдөлмөр, халамжийн ерөнхий газрын дарга баталж мөрдүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд төслийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээний үүргээ зөрчсөн иргэний төслийг буцаан татаж, гэрээг цуцлах, хуульд заасан арга хэмжээг авч ажиллах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Төсөл хэрэгжүүлэгчтэй эрх зүйн чадамжтай гэрээг байгуулж, баталгаажуулах, гэрээний хэрэгжилтийг дүгнэж, үр дүнг тооцож ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.3.2 ХЭДС-гийн хөрөнгийн зарцуулалтыг үнэн зөв тайлагнасан байна.

Аймгийн ХЭДС-гийн санхүүгийн тайлангаар 2019 онд 603,474.6 мянган төгрөгийн орлого, 396,478.8 мянган төгрөгийн зарлага, 2020 онд 478,865.7 мянган төгрөгийн орлого, 298,775.2 мянган төгрөгийн зарлага бүртгэж тайлагнасан байна.

ХЭДС-гийн нийт авлага 2019 онд 371,912.5 мянга, 2020 онд 405,139.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

ХЭДС-гийн орлого, зарлага, авлага, өглөгийн төсвийн мэдээг сар бүр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлж хэвшсэн байна.

ХЭДС-гийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх

Бүлэг 3

Дотоод хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий зөвлөл болон эрх бүхий албан тушаалтан хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

3.1. Сангийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтын тогтолцоо үр нөлөөгүй, хөндлөнгийн байгууллагаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгээгүй байна.

3.1.1 ХЭДС-гийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих шат шатны дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2019-2020 онд ХЭДС-гийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих төлөвлөгөө гаргаагүй, хяналт хийсэн ажлын тайлангүй, ямар зөрчил илрүүлж, ямар зөвлөмж өгсөн нь тодорхойгүй байна.

Харин ХХҮГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 2019 онд 14 удаа, 2020 онд 4 удаа ХЭДС-гийн хөрөнгийн зарцуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлж, төсөл хөтөлбөрийг газар дээр нь очиж уулзан зураг авалт хийж, зээлийн эргэн төлөлтийн



угацаа хоцроосон иргэдэд зээлээ төлөх мэдэгдэх хуудас хүргүүлэн ажилласан боловч хяналт хийсэн талаарх тайлагналт, авсан арга хэмжээ тодорхойгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлөөс 2019 онд ажлын төлөвлөгөө баталсан боловч биелэлтийг гаргаагүй, 2020 онд ажлын төлөвлөгөө батлаагүй, сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй байна. ХЭАЗ-ийн гишүүдэд 2019 онд 4,000.0 мянга, 2020 онд 3,300.0 мянга нийт 7,300.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон боловч гүйцэтгэсэн ажлын үр дүнтэй уялдаагүй байна.

Энэ нь ХЭҮЗ-ийн 2017 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.1.4-т “Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр батлагдсан хөтөлбөрүүд болон орон нутгийн онцлогтой хөтөлбөр төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтийг нь удирдан зохицуулах, биелэлтэд нь хяналт тавих, 2.1.5-д “тухайн орон нутгийн хөдөлмөр эрхлэлт дэмжих дэд сангийн төсвийг бүрдүүлэх, хуваарилах асуудал хэлэлцэж зөвлөмж гаргах, сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавьж, санхүүгийн тайланг хагас бүтэн жилээр хэлэлцэж дүгнэлт гаргах, 2.2.3-т “хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн орлого, зарлагын явц, байдал үүний дотор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийн эргэн төлөлтийн байдалд хяналт тавих” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд дээрх дүрмийн дагуу холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах, зөвлөлийн ажлын төлөвлөгөөг жил бүр батлан гаргаж, зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хэрэгжилтийг ханган ажиллах, байгууллагын дотоод хяналтын тогтолцоо, чиг үүрэг бүхий ажилтны ажлын үр дүнг сайжруулах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.1.2 ХЭДС-гийн 2019 оны үйл ажиллагаанд аймгийн МХГ-аас хяналт шалгалт хийгдсэн бөгөөд хөндлөнгийн байгууллагаар ХШҮ хийлгээгүй байна.

ХЭДС-д МХЕГ-ын даргын 2019 оны 01/221 тоот “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт” удирдамжийн дагуу аймгийн МХГ-аас “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилт, гүйцэтгэл, үр дүнд хяналт шалгалтыг хийсэн байна. Уг хяналт шалгалтаар санхүүгийн дэмжлэгт хамрагдсан боловч төслийн хэрэгжилт хангалтгүй, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг гэрээний хуваарийн дагуу төлөөгүй нийт 8 иргэн, 1 аж ахуй нэгж байгууллагад нийт 113,879.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон байна.

Хяналт шалгалтын мөрөөр актыг барагдуулах арга хэмжээг авч, 3 иргэн, 1 аж ахуй нэгж байгууллагын нийт 90,076.0 мянган төгрөгийн актыг барагдуулж, хэрэгжилт 80.0%-тай, үлдэгдэл 4 иргэний 18,803.9 мянган төгрөгийг төлүүлэхээр шүүхийн шийдвэр гаргуулж, 5,000.0 мянган төгрөгийн 1 иргэний зээлийг төлүүлээгүй нь тус иргэн сураггүй алга болсонтой холбоотой хэрэгжүүлээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд **хөндлөнгийн байгууллагаар жил бүр** хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэнэ”, “Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, хяналт тавих журам”-ын 5 дугаар зүйлийн 5.4-д “Сангийн үйл ажиллагаанд мэргэшсэн байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд жил бүр танилцуулна” гэж заасан боловч хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгээгүй байна.



Иймд дээрх хууль, журмын дагуу хөндлөнгийн байгууллагаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.2.ХЭДС-гийн мэдээ, тайлангийн гүйцэтгэлийг үнэн зөв, хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

3.2.1 ХЭДС-гийн орлого, зарлагын тайланг холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.1.1, 25.1.2, Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын дугаар зүйлийн 5.5-т заасны дагуу ХЭДС-гийн 2019, 2020 оны сар бүрийн төсвийн мэдээ, авлага, өглөгийн мэдээ насжилтаар, төсвийн гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн тайланг ХХҮЕГ-т хуулийн хугацаанд нь хүргүүлэн ажиллаж хэвшсэн байна.

Мөн Статистикийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5, 6 дугаар зүйлд заасны дагуу ХЭД хөтөлбөрүүдийн мэдээ тайланг сар бүр АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст, хөдөлмөр эрхлэлтийн статистик тоо, мэдээ тайланг ХХҮЕГ болон аймгийн Статистикийн хэлтэст тус тус хүргүүлж ажилласан байна.

3.2.2 ХЭДС-гийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл гомдол, санал гараагүй байна.

Аймгийн ХЭДС-д төсөл хөтөлбөрт хамрагдахаар 2019 онд 300 иргэн, 2020 онд 133 иргэн өргөдөл гаргаж тус тус төсөл хөтөлбөрт хамрагдсан байна

Харин 2019-2020 онд аймгийн ХЭДС-гийн үйл ажиллагаатай холбоотой иргэдээс гомдол, санал гараагүй байна.

3.2.3 ХЭДС-гийн орлого, зарлагын тайланг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн хугацаанд үнэн зөв, бүрэн мэдээлсэн байна.

ХЭДС нь 2019 онд Шилэн дансны цахим хуудсанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг 5 дугаар сард хугацаа хоцроосон, бусад бүх мэдээллийг 2019, 2020 онд хуулийн хугацаанд нь үнэн зөв мэдээлсэн байна.

Аймгийн СХАА-наас 2019-2020 оны шилэн дансны хэрэгжилтэд хяналт тавьж, 100%-тай үнэлсэн байна.

Тус гүйцэтгэлийн аудитаар 90,651.9 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх 13,000.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, үйл ажиллагааны үр дүнг сайжруулах чиглэлээр 8 зөвлөмж өглөө.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-1

- Орлогын төлөвлөлтөд орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилах боломжит нөхцөл байдлыг судлаагүй, аймгийн ИТХ-д санал хүргүүлээгүй байна

Бүлэг -2

- ХЭДС-гийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан боловч төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг тооцож дүн шинжилгээ хийгээгүй байна.

Бүлэг -3

- Дотоод хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий зөвлөл болон эрх бүхий албан тушаалтан хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, хяналт тавих журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах, сангийн жил бүрийн төсвийг хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлөөр хэлэлцэж байх
2. ХЭҮЗ-ийн 2017 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрмийн дагуу сангийн үйл ажиллагаанд хяналт тавих холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах, зөвлөлийн ажлын төлөвлөгөөг жил бүр батлан гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллах, зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргад:

1. Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санг байгуулах хэрэгцээ шаардлага байгаа эсэх, санд орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилах нөхцөл боломжийг судлах
2. Тухайн жилд хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл хөтөлбөр болон сонгон шалгаруулалтын зар мэдээллийг зорилтот хэрэглэгчдэд үр дүнтэй хүргэх ажлыг зохион байгуулах
3. Сангийн зорилтот түвшинг өмнөх оны түвшингээс бууруулахгүй төлөвлөж, тухайн жилд дэвшүүлсэн зорилтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах, зорилтот түвшиндээ хүрээгүй хөтөлбөрүүдэд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, үнэлж ажиллах
4. Төсөл хэрэгжүүлэгчийн нийгмийн даатгалд хамрагдах хувийг нэмэгдүүлэх, жижиг зээлийн хүрээнд ажлын байр бий болгохоор олгосон төслийн үр дүнг сайжруулж, талууд гэрээний үүргийг биелүүлэхэд анхаарч ажиллах
5. Төсөл хэрэгжүүлэгчтэй эрх зүйн чадамжтай гэрээг байгуулж, баталгаажуулах, гэрээний хэрэгжилтийг дүгнэж, үр дүнг тооцож ажиллах
6. Дотоод хяналт шалгалт үр дүн муутай, тайлагналт хангалтгүй байгаа тул байгууллагын дотоод хяналтын тогтолцоо, чиг үүрэг бүхий ажилтны ажлын үр дүнг сайжруулах, ХЭДС-гийн үйл ажиллагаанд хөндлөнгийн байгууллагаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэж байх

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,

Утас/Факс: (976) 7054 3518,

E-mail: govissumber.hudulmur.halamj@gmail.com

№ 06.28 № 02/282

танай 06.28 ны № 188 -т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад холбогдох санал, тайлбарыг хүргүүлж байна.

Хавсралт 1. хуудас

ДЭД ДАРГА



Т. БАЯСГАЛАН

Ц. Батсодханд
Майлбартай
танилцаан, тайлан
хүснэгт батал-
гажүүлэх
Анх

D:\бичиг хэрэг\A5 1 тоот.docx

27
33



Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын
2021 оны 6 дугаар сарын 8 өдрийн 02 тоот
албан бичгийн хавсралт

САНАЛ ТАЙЛБАР:

4. 2019-2020 онд хэрэгжүүлсэн "Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн нийтийг хамарсан арга хэмжээг хамтран хэрэгжүүлсэн ажил олгогчдын 65351,9 мян төгрөгийн төсөл хэрэгжүүлэх гэрээг батлагдсан хөтөлбөр, удирдамжийн дагуу хэрэгжүүлж, гүйцэтгэлд тухай бүр хяналт тавьж, арга хэмжээнд хамрагдсан иргэдэд "хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээ"-гээр цалин, урамшууллыг тооцож олгосон. Иймд 65351,9 мян төгрөгийн албан шаардлагыг зөвлөмж болгоно уу.

5. 2019 онд ажил хөдөлмөр эрхэлдэг -2, 2020 онд ажил хөдөлмөр эрхэлдэг - 6 иргэнд тус бүрийн санхүүгийн дэмжлэг олгосон гэх зөрчлөөс Өлзийн Ганбат, Жунайн Ганхуяг, Дашзэвэгийн Доржсүрэн, Мандуулай Алтанхуяг, Төмөртоого Лхагвасүрэн, Сайнчулуун Сугирмаа, Батпүрэв Золбоо нар нь ХЭД хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэг арга хэмжээнд хамрагдах үед байнгын ажил хөдөлмөр эрхлээгүй, ажилгүй иргэд байсан тул албан шаардлагын дүнгээс хасч өгнө үү.

ХЯНАСАН:
ХЭХ-ИЙН ДАРГА Г.БОЛОРТУЯА

САНАЛ ТАЙЛБАР НЭГТГЭСЭН:
ХШУХАМЭРГЭЖИЛТЭН: Б.ЭНХДЭЛГЭР





ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

Шалгагдагч байгууллагаас тайлангийн төсөлд ирүүлсэн саналтай танилцаад тайланд дараах өөрчлөлт оруулж байна.

Санал-1: 2019-2020 онд хэрэгжүүлсэн “ажлын байрны дэмжих хөтөлбөр”-ийн нийтийг хамарсан арга хэмжээг хамтран хэрэгжүүлсэн ажил олгогчдын 65,351.9 мянган төгрөгийн төсөл хэрэгжүүлэх гэрээг батлагдсан хөтөлбөр, удирдамжийн дагуу хэрэгжүүлж, гүйцэтгэлд тухай бүр хяналт тавьж арга хэмжээнд хамрагдсан иргэдэд “хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээгээр цалин, урамшууллыг тооцож олгосон. Иймд 65,351.9 мянган төгрөгийн албан шаардлагыг зөвлөмж болгоно уу.

Тайлбар-1: Саналын дагуу алдаа, зөрчлийн үр нөлөөг үнэлж, цаашид төсөл хэрэгжүүлэгч нартай эрх зүйн чадамжтай гэрээг байгуулж, баталгаажуулах, гэрээний хэрэгжилтийг дүгнэж, үр дүнг тооцож ажиллах зөвлөмж болгон өөрчлөлт орууллаа.

Санал-2: 2019 онд ажил хөдөлмөр эрхэлдэг 2, 2020 онд ажил хөдөлмөр эрхэлдэг 6 иргэнд тус бүрийн санхүүгийн дэмжлэг олгосон гэх зөрчлөөс Ө.Ганбат, Ж.Ганхуяг, Д.Доржсүрэн, М.Алтанхуяг, Т.Лхагвасүрэн, С.Сугирмаа, Б.Золбоо нар нь ХЭД хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэг арга хэмжээнд хамрагдах үед байнгын ажил хөдөлмөр эрхлээгүй, ажилгүй иргэд байсан тул албан шаардлагын дүнгээс хасаж өгнө үү

Тайлбар-1: Аудитын явцад аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс гаргуулан авсан тулган баталгаажуулалтыг алдаатай гарган ирүүлж хариуцлагагүй хандсан байна. Энэ талаар тухайн байгууллагад албан тоот хүргүүлсэн болно. Тус байгууллагын 2021.05.31-ний өдрийн 124 тоотор ирүүлсэн НДШ төлсөн талаарх мэдээлэл нь алдаатай ирсэн тул албан шаардлагын дүнгээс 7 иргэний 21,500.0 мянган төгрөгийн зөрчлийг бууруулан тайланд өөрчлөлт оруулав.